



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 09-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Говь ХК-ийн 2020 оны санхүүгийн үр дүнг харгалзан, компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байх нь зүйтэй гэж үзэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дугаар заалт болон Компанийн дүрмийн 8.9 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК нь 2020 оны санхүүгийн тайлангаар санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Говь ХК нь хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д даалгасугай.

Гурав. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нарантуяа/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

